



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 08 сарын 11 өдөр

Дугаар А/467

Эрдэнэт

Тэмцээнд оролцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, 29.2 дахь заалт, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.10 дахь заалт, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/47 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Батлан хамгаалахын сайд Орхон аймгийн Засаг даргатай 2017 онд хамтран ажиллах гэрээний дагуу Батлан хамгаалахын сайдын нэрэмжит улсын аварга шалгаруулах цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээнд аймгаас орох баг тамирчдын бэлтгэлийг тэмцээний удирдамж, зааврын дагуу сайтар хангаж оролцуулахыг Цэргийн штабын дарга, хурандаа Г.Батсуурьт үүрэг болгосугай.

Хоёр. Батлан хамгаалахын сайдын нэрэмжит улсын аварга шалгаруулах цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээнд оролцоход шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

Гурав. Улсын аварга шалгаруулах цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээнд оролцоход шаардагдах 4984500 / Дөрвөн сая есөн зуун наян дөрвөн мянга таван зуун / төгрөгийг аймгийн 2016 оны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит IV хуралдааны 02 дугаар тогтоолоор батлагдсан Орон нутгийн хамгаалалтыг зохион байгуулах, удирдлага зохион байгуулалтыг бэхжүүлэх зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны 08 дугаар сарын 11-ны өдрийн 2 дугаар захирамжийн хавсралт

ЦЭРЭГ-СПОРТЫН "ДӨЛ" ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХОД  
ШААРДАГДАХ ТӨСВИЙН ТООЦОО

| №                                  | Зардлын нэр  | Тоо хэмжээ | Нэгж   | Нэгжийн үнэ    | Нийт үнэ           |
|------------------------------------|--|------------|--|----------------|--------------------|
| <b>1.Хувцас хэрэглэлийн зардал</b> |  |            |  |                |                    |
| 1.                                 | Тасгийн бүрэлдэхүүний ижил, өнгө, загварын дүрэмт хувцас   | хос        | 13   | 102000         | 1326000            |
| 2.                                 | Тасгийн бүрэлдэхүүний ижил, өнгө, загварын дүрэмт хувцасны малгай  | ширхэг     | 13   | 0              | 0                  |
| 3.                                 | Дүрэмт хувцасны загварт тохирсон хагас түрийтэй гутал  | хос        | 13   | 0              | 0                  |
| 4.                                 | 40x40 см-ийн хэмжээтэй тасгийнхаа онцлогийг илэрхийлсэн дарцаг   | ширхэг     | 1  | 25000          | 25000              |
| 5.                                 | Аймгийн онцлогийг тусгасан ялгах тэмдэг  | ширхэг     | 15   | 4000           | 60000              |
| <b>Бүгд</b>                        |  |            |  |                | <b>1411000</b>     |
| <b>2.Хоол,цай ундааны зардал</b>   |  |            |  |                |                    |
| 1.                                 | Тэмцээнд оролцох бэлтгэл хийж байгаа 15 хүний зөвхөн өдрийн хоол /2017 оны 08 дугаар сарын 21-ний өдрөөс 09 дүгээр сарын 09-ийг хүртэл 15 хоног/                       | өдөр       | 15 өдөр /өдрийн хоол/  | 4000 /15 хүн/  | 900000             |
| 2.                                 | Улаанбаатар хот Зэвсэгт хүчний нэгдсэн сургалтын төвд тэмцээнд оролцож байгаа 18 хүний /2017 оны 09 дүгээр сарын 13-нээс 23-ыг хүртэл 10 хоног/                        | хоног      | 10 хоног /өглөө,өдөр, оройн хоол/                                    | 6000 /18 хүн/  | 1080000            |
| <b>Бүгд</b>                        |  |            |  |                | <b>1980000</b>     |
| <b>3.Тээврийн зардал</b>           |  |            |  |                |                    |
| 1.                                 | Аймгийн ЗДТГ-Говил -ЗХ-ний 186 дугаар анги-аймгийн ЗДТГ хүртэл маршрутаар явах /2017 оны 08 дугаар сарын 21-ний өдрөөс 09 дүгээр сарын 09-ийг хүртэл 15 хоног/         | өдөр       | A-92 /өдөрт 10 л /   | 1650 /15 өдөр/ | 247500 /бүгд 150л/ |
| 2.                                 | Эрдэнэт-Улаанбаатар-Төв аймгийн Алтанбулаг сум ЗХ-ний нэгдсэн сургалтын төв- Эрдэнэт -Автобус 25 хүний суудалтай-1 нэгж -ЗДТГ-ын 00-64 ора- дугаарын автомашин -1 нэгж |            | A-92 /Автобус 100 км-т 16 л, Mazda-100 км-т 14 л шатахуун зарцуулна/ | 1650           | 495000 /300л/      |
| 3.                                 | Улаанбаатар хот Зэвсэгт хүчний нэгдсэн сургалтын төвд тэмцээний бэлтгэлийг хангах, бусад үйлчилгээний ажилд  | хоног      | A-92 /өдөрт 10 л /   | 1650 /14 өдөр/ | 231000 /140л/      |
| <b>Бүгд</b>                        |  |            |  |                | <b>973500</b>      |

| <b>4. Гэнэтийн ослын даатгалын зардал</b> |   |                |    |       |                |
|---|---|----------------|----|-------|----------------|
| 1   | Тэмцээнд оролцож байгаа бүрэлдэхүүнийг гэнэтийн ослын даатгалд даатгуулах |                | 13 | 10000 | 130000         |
| <b>Бүгд</b>                               |   |                |    |       | <b>130000</b>  |
| <b>5. Засвар тохижилтын зардал</b>        |   |                |    |       |                |
| 1   | Цэргийн штабын танхимын засвар тохижилтын ажилд эмульс                    | кг             | 28 | 6000  | 168000         |
| 2   | Шалны хулдаас наах цавуу  | кг             | 16 | 8500  | 136000         |
| 3   | Шалны хулдаас   | М <sup>2</sup> | 8  | 10000 | 80000          |
| 4   | Сантехник, агааржуулалтын хоолой болон бусад гагнуурын ажилд              | ширхэг         |    |       | 106000         |
| <b>Бүгд</b>                               |   |                |    |       | <b>490000</b>  |
| <b>Нийт</b>                               |   |                |    |       | <b>4984500</b> |